



**КРЕДИТ**

ЖИЛИЙН ТАЙЛАН

**MSE:**  **ADB**



# Агуулга

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	6
Компанийн тухай	9
2020 онд Ард Кредит	11
2020 оны онцлох үйл явдал	12
Санхүүгийн гол үзүүлэлт	14
Засаглал	16
Хувьцаа эзэмшигчдийн бүтэц	17
Хувьцааны арилжаа	18
Төлөөлөн Удирдах Зөвлөл	19
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Хороод	22
Ногдол ашгийн тайлан	24
Үйл ажиллагаа	26
Хүний нөөц	28
Нийгмийн хариуцлага	31
Эдийн засгийн орчин	32
Банк бус санхүүгийн байгууллагын зах зээл	36
Хараат бус аудитын тайлан	
Хамтран ажиллагч байгууллагууд	





### **Эрхэм зорилго**

Ирээдүйн ур чадвар, технологийг цаг хугацааны товчлолоор авчирч, тогтвортой хөгжлийг түргэтгэж, өндөр өгөөжийг бий болгоно.

### **Алсын хараа**

Салбарын хөгжлийг түүчээлнэ.

### **Үнэт зүйлс**

Хамтдаа хуваалцах  
Тогтвортой хөгжих  
Хүлээлтээс давж үйлчлэх  
Хүртээмжтэй, тэгш оролцоог бүрдүүлэх  
Ёс зүйтэй байх

# Гүйцэтгэх захирлын илгээлт

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, харилцагч, хамтран ажиллагсад та бүхний амар амгаланг эрье.

2020 он дэлхий дахинд нийгэм, улс төр, бизнесийн салбарт шинэ хандлага, өөрчлөлтийг авчирсан онцгой цаг үе байсан бол Ард Кредит хувьцаат компанийн (MSE:ADB) хувьд Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекст багтсан, дэд бүтэцдээ томоохон хөрөнгө оруулалтуудыг үе шаттай хийх замаар олон шинэлэг өөрчлөлтүүдийг хийж, салбартаа манлайлсан бүтээлч он цаг байлаа.

Цар тахал дэгдэж, нийгэм, эдийн засгийн амьдралд гэнэтийн эргэлт гарсан цаг үед бид ажиллагсад, харилцагчдынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг зайнаас явуулах горимд яаралтай шилжүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлаа цахимаар зохион байгуулсан нь компанийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн үргэлжлүүлэхэд чухал алхамууд байв.

Зээл олголтыг тасралтгүй үргэлжлүүлэх, зээлийн эргэн төлөлтийн уян хатан нөхцөлийг харилцагчдадаа санал болгох, бизнесийн зээлийн шимтгэлийг тэглэх, хариуцлагатай харилцагчдаа тогтмол урамшуулах зэрэг нь нийгмийн амьдралд шинэ өөрчлөлт, шинэ дэглэм авчирсан онцгой цаг үед авч хэрэгжүүлсэн компанийн тэргүүн зорилт, цар тахлын эсрэг хариу арга хэмжээ байлаа.

Монголбанкнаас Цахим мөнгө гаргах тусгай зөвшөөрөл авч, АрдКэш цахим мөнгийг хэрэглээнд нэвтрүүлэхийн зэрэгцээ стратегийн түнш Монгол Шуудан ХК-тай хамтран дэлхийн өнцөг булан бүрт 500 мянга гаруй салбар нэгжтэй EuroGiro байгууллагын олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүллээ.

Ингэснээр гадаад улсад амьдардаг иргэд гэр бүл рүүгээ мөнгө шилжүүлэхийн тулд заавал банкны үйлчилгээг авалгүйгээр, хамгийн бага шимтгэлтэйгээр мөнгөн гуйвуулга хийх боломжтой болж байгаа юм.



АрдКэш нь Ард Санхүүгийн Нэгдлээс зах зээлд нэвтрүүлсэн, Ард Аппаар төлбөр тооцоо хийхэд ашиглагдах, цахим хэлбэрээр хадгалагдах мөнгөн хөрөнгөөр баталгаажсан цахим мөнгө юм. АрдКэш нь төгрөгт, төгрөг нь АрдКэшд чөлөөтэй хөрвөх боломжтой байдаг тул Ард Аппын хагас сая хэрэглэгчид зээл авах, үнэт цаасны арилжаанд оролцох, онлайн худалдаа хийх, мөнгө гуйвуулах, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн олон төрлийн үйлчилгээг Ард Апп-аар дамжуулан нэг дороос авах боломжтой болсон билээ.

Оны төгсгөлд бид банк хоорондын төлбөр тооцооны АСН+ (Автомат Клиринг Хаус) системд нэгдэж 3 сая хүртэлх төгрөгийн бага үнийн дүн бүхий гүйлгээг бодит цагийн горимд, 24/7 зарчмаар тасралтгүй дамжуулах боломжийг харилцагчдадаа олгож эхлээд байна.

Компанийн голлох бүтээгдэхүүнүүдийн нэг болох “Fast Cash” цахим зээлийг хөдөө орон нутагт нэвтрүүлж эхэлсэн нь цаашид Монгол орны өнцөг булан бүрт санхүүгийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлэх бидний Алсын хараа юм.

2020 оны эцсээр манай компани 2,139 хувьцаа эзэмшигч, 350 мянга гаруй харилцагчтай болсон бол энэхүү мэндчилгээ бичигдэж байх үед бид Ард Аппын 4 дэх хувилбарыг олон нийтэд танилцуулж, Монголын Хөрөнгийн Бирж дээр манай хувьцаа түүхэн дээд ханшдаа хүрч, нийт 6,500 хувьцаа эзэмшигч 900 мянга гаруй харилцагчидтай болж, Монголын Банкны Холбоонд албан ёсны гишүүнчлэлтэй байгууллага болоод байгааг дуулгахад таатай байна.

Цаг үеийн нөхцөл байдлыг үл харгалзан бидэнтэй хамт байж, бидэнд итгэл үзүүлсэн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, хамтран ажиллагсад та бүхэндээ эрүүл энх, ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Хүндэтгэсэн  
**Гүйцэтгэх захирал**

**Г.Тэлмэн**

# Компанийн тухай

Ард Кредит нь 2011 онд Интергрупп Интернэйшнл ХХК-ийн хөрөнгө оруулалтаар байгуулагдаж, 2013 онд Ард Санхүүгийн Нэгдэл хөрөнгө оруулалт хийснээр шинэ удирдлага, стратегиар ажиллаж эхэлсэн салбартаа тэргүүлэгч Банк Бус Санхүүгийн Байгууллагын нэг билээ. Ард Кредит нь техник, технологийн дэвшлийг ашиглан Монгол улсын өнцөг булан бүрт санхүүгийн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Мөн 2019 оны I улиралд компанийн 25% болох 70,000,000 ширхэг хувьцааг олон нийтэд нээлттэй санал болгож, хувьцаат компани болсноос хойш жил хүрэхгүй хугацаанд хувьцаа эзэмшигчдэдээ цэвэр ашгийн 50% болох 1.09 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр тараан, Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекст 2 дахь удаагаа багтаад байгаа юм. Энэхүү тайлан харилцагч таны гарт хүрэх үед бид Ард Аппын 4 дэх шинэчилсэн хувилбарыг олон нийтэд танилцуулж, 900 мянга гаруй харилцагч, 6,500 орчим хувьцаа эзэмшигчтэй болж нэгж хувьцааны үнэ бүх цаг үеийн хамгийн дээд 275.06 төгрөгийн ханшид хүрээд байна.

## 2011

Интергрупп Интернэйшнл ХХК-ийн хөрөнгө оруулалтаар үүсгэн байгуулагдав.

## 2013

Ард Санхүүгийн Нэгдэл ХК хөрөнгө оруулалт хийснээр шинэ удирдлага, стратегитайгаар ажиллаж эхлэв.

## 2014

СЗХ-ны зөвшөөрлөөр анхны хаалттай өрийн бичгээ амжилттай гаргаж нийт 550 сая төгрөгийн санхүүжилт босгов.

Хувьцаа эзэмшигчдэдээ анхны ногдол ашиг хуваарилав.

Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагааны чиглэлээ өргөжүүлэв.

Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан-тай хамтран ажиллаж, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой айл өрхүүдэд хөнгөлөлттэй зээл олгож эхлэв.



## 2015

Хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж, Ард Санхүүгийн Нэгдэл нь компанийн 58 хувийг эзэмших болов.

Бичил Санхүүгийн Хөгжлийн Сангаас хөнгөлөлттэй санхүүжилт авч, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зээл олгож эхлэв.

Хөдөөгийн бичил санхүүгийн байгууллагуудад бөөний зээл олгож эхлэв.

## 2017

ББСБ-уудаас анхлан Кредит картын бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ББСБ-уудаас салбартаа хамгийн бага зээлийн хүүтэй байгууллага болон ажиллаж эхэлсэн.

ГрэйпСити Монгол ХХК-тай стратегийн түвшинд хамтран ажиллахаар болж, Поларис үндсэн банкны систем болон Мост Мони үйлчилгээг нэвтрүүлэх гэрээ байгууллаа.

2017 оны 6 сарын 22-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллав.

## 2018

Олон улсын мөнгөн гуйвуулгын EuroGiro систем болон Монгол Шуудан ХК-тай хамтран Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг амжилттай эхлүүлэв.

Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос IPO хийх зөвшөөрөл аван үнэт цаасаа бүртгүүлэв.

Санхүүгийн Зохицуулах Хорооноос Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээний тусгай зөвшөөрөл авав.

Компанийн ТУЗ нь 2017 онд цэвэр ашгийн 50 хувийг хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хэлбэрээр хуваарилах шийдвэр гаргав.

Япон улсын Крауд Кредит хөрөнгө оруулалтын сангаас 13 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт авах тухай хэлэлцээр хийгдэж, 2019 оны I улиралд эхний санхүүжилтийг хүлээн авахаар боллоо.

Овердрафтын зээлийн бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлэв. Хүүгүй, барьцаагүй зээлийг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.

ББСБ-уудаас салбартаа анхлан хувьцаа барьцаалсан зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.

ГрэйпСити Монгол ХХК-ийн банкны үндсэн систем болох Поларис системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэв.

Санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх Ард Аппын эхний хувилбарыг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.

Ард Санхүүгийн Нэгдлийн санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлэх салбар Сэнтрал Тауэрт нээгдэж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос салбарын тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагаагаа явуулж эхлэв.

## 2019

Монгол Шуудан ХК-ийн салбаруудаар дамжуулан харилцагчиддаа санхүүгийн үйлчилгээгээ хүргэж эхлэв.

2019 оны I улиралд хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны захиалга төлөвлөснөөс 299 хувь даван биелэв. Ингэснээр олон нийтээс 5.3 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлж, 1,500 гаруй шинэ хувьцаа эзэмшигчтэй нээлттэй хувьцаат компани болов.

Япон улсын Крауд Кредит хөрөнгө оруулалтын сантай хийсэн 5 сая долларын санхүүжилтын хэлэлцээрийн дагуу, 9 удаагийн санхүүжилтээр 2.4 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэв. Хувьцаат компани болон хэлбэрээ өөрчилсний дараах анхны хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2019 оны 4 сарын 27-ны өдөр 81%-ийн ирцтэйгээр амжилттай зохион байгуулав.

Дэлхийн 36 улсын 100 гаруй байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн, Варшав хотод байршилтай “Бичил Санхүүгийн Төв”-өөс зохион байгуулсан хурлын Алтан спонсороор ажиллаж, баг, хамт олноороо амжилттай оролцсон. Гадны олон зочид хуран чуулсан уг хурлаар Ард Аппыг олон улсын хөрөнгө оруулагчдад албан ёсоор танилцуулав.

# 2020 оны онцлох үйл явдал

Монголын Хөрөнгийн Биржийн 2020 оны ТОП-20 индексийн сагсанд Ард Кредит ББСБ ХК багтав.

Ард Кредит ББСБ ХК-ийн гүйцэтгэх захирлаар Г.Тэлмэн томилогдон ажиллаж эхлэв.

2019 оны цэвэр ашиг болох 2.2 тэрбум төгрөгийн 50% буюу 1.1 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэж 4 сарын 30-нд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компаниудаас хамгийн түрүүнд ногдол ашгаа хувьцаа эзэмшигчдэдээ тараав.

Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих BEST хөтөлбөрийн хүрээнд Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулж зээлдэгчдийн боловсролын чиглэлээр ажиллаж эхлэв.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг анх удаа цахимаар 85.21% ирцтэйгээр амжилттай зохион байгуулав.

Монголбанкнаас Ард Кредит ХК-д Цахим мөнгө гаргах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосноор банкны төлбөр тооцооны үйлчилгээнд оролцож эхлэв.

Япон улсын Крауд Кредит сангийн санхүүжилтийн эргэн төлөлтийг өөрийн эх үүсвэрээр амжилттай гүйцэтгэв.


Хөрөнгө Оруулагч Үндэстэн орон нутагт хөтөлбөрийн хүрээнд Баянхонгор, Өвөрхангай аймгуудад Fast Cash цахим зээл олгож эхлэв.

EuroGiro Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 10 сарын 2-ны өдөр Монгол Шуудан ХК-тай хамтран зах зээлд нэвтрүүлэв.

АСН+ (Автомат Клиринг Хаус) банк хоорондын шууд гүйлгээний системийг амжилттай нэвтрүүлэв.

# 2020 онд Ард Кредит

Харилцагч  
356.8 мянга



Апп таталт  
637.0 мянга

**Олгосон зээл**  
₮ 42.1 тэрбум

**Зээлийн багц**  
₮ 20.3 тэрбум

**Зээл эргэн төлөлт**  
₮ 44.2 тэрбум

**Зээлдэгч**  
48.6 мянга

**Зээлийн хүсэлт**  
467.7 мянга

**Нийт хөрөнгө**  
₮ 29.6 тэрбум


**Санхүүжилт**  
₮ 15.0 тэрбум

**Нийт ашиг**  
₮ 2.1 тэрбум

# Санхүүгийн гол үзүүлэлт

## Санхүүгийн гол үзүүлэлт (аудитлагдаагүй тайлан)

### Чанаргүй зээл




### Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар




### Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа




### Өрийн харьцаа



### Нийт хөрөнгө (сая төг)



### Цэвэр зээл (сая төг)



Санхүүжилтийн өглөг (сая төг)

2018	6,186
2019	10,879
2020	15,039

Өөрийн хөрөнгө

2018	3,757
2019	10,692
2020	11,253

Үйл ажиллагааны ашиг (сая төг)

2018	369
2019	3,226
2020	2,890

Нийт ашиг (сая төг)

2018	342
2019	2,187
2020	2,071

Тодруулга: “Грант Торнтон аудит” ХХК-иас ирүүлсэн зөвлөмжийн дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг Санхүү байдлын тайландаа тусгасан. Уг өөрчлөлтийн үр дүнд виртуал хөрөнгийг биет бус хөрөнгийн ангилал руу шилжүүлэн бүртгэсэн ба нийт ашиг 2.1 тэрбум төгрөг, үүнээс цэвэр ашиг 1.2 тэрбум төгрөг, бусад дэлгэрэнгүй орлого 0.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарлаа.



# Засаглал

## Хувьцаа эзэмшигчдийн хурал

Ард Кредит ББСБ ХК нь Монголын Хөрөнгийн Биржийн хувьцааны бүртгэлийн I ангилалд багтдаг нээлттэй, хувьцаат компани билээ. 2019 онд Ард Кредитын хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны дараа 1,454 хувьцаа эзэмшигчтэй байсан бол 2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар бид 2,139 хувьцаа эзэмшигчтэй болсон байна.

Ард Кредит ББСБ ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд түүний чөлөө цагт компанийн үйл ажиллагааг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон 9 гишүүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн Удирдах Зөвлөл удирдана. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн

дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийг өөрчлөн байгуулах, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнийг сонгох, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах, компанийн хэлбэрийг өөрчлөх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг байна.

Компани 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг [live.ard.mn](http://live.ard.mn) сайтаар зохион байгуулж, 238,600,207 ширхэг саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид оролцож, 85.21 хувийн ирцтэйгээр хуралдан Ард Кредит ББСБ ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах шийдвэр гаргасан юм.






# Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

(2020 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар)

#	Хувьцаа эзэмшигч	2020.12.31	Хувь
1	Ард Санхүүгийн Нэгдэл ХК	171,499,776	61.25%
2	С.Гэрэлтуяа	27,296,413	9.75%
3	Ард Лайф ХХК	9,824,462	3.51%
4	И.Баттуяа	5,823,084	2.08%
5	А.Сүхдорж	5,086,580	1.82%
6	И Ай Ти ХХК	4,974,060	1.78%
7	Ард Лизинг ХХК	4,230,770	1.51%
8	Ард Даатгал ХК	3,781,607	1.35%
9	Моннис Интернэйшнл	3,705,071	1.32%
10	Н.Даваасүрэн	3,571,428	1.28%
<b>Топ хувьцаа эзэмшигчид</b>		<b>19,613,979</b>	<b>84.36%</b>
Бусад хувьцаа эзэмшигчид		7,561,650	13.69%
<b>Эргэлтэнд байгаа хувьцаа</b>		<b>273,560,449</b>	<b>97.7%</b>
Халаасны хувьцаа		6,439,551	2.3%
<b>Нийт зарласан хувьцаа</b>		<b>280,000,000</b>	<b>100.0%</b>
<b>Хувьцаа эзэмшигчдийн тоо</b>		<b>2,139</b>	

# Хувьцааны арилжаа



52 долоо хоног	₮60.1 - ₮82.1
Зах зээлийн үнэлгээ	₮ 22.46 тэрбум
Нийт хоёрдогч арилжааны дүн	₮2.2 тэрбум
Хаалтын үнэ	₮82.1
Дансны үнэ	₮40.9
P/E- Үнэ/ашиг	11.1
P/B - Үнэ/Дансны үнэ	2.0

# Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурал

Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (Цаашид “ТУЗ” гэх) нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах зэрэг Компанийн тухай хууль, компанийн дүрмийн дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлуудаар шийдвэр гаргаж ажилладаг.

2019 оны 4 сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-ийн гишүүдийг 3 жилийн хугацаатай сонгосон бөгөөд Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-д “Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн

удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна” гэж заасны дагуу өнөөдрийн байдлаар 5 ердийн, 4 хараат бус гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. ТУЗ-ийн даргаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирал Чулууны Ганхуяг ажиллаж байна.

ТУЗ-өөс жил бүр компанийн стратеги, зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, улирал тутам хуралдан төлөвлөгөөний биелэлтийг тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлгийг өгч ажиллаж байна.



Чулууны  
**Ганхуяг**  
Төлөөлөн Удирдах  
Зөвлөлийн дарга



Сэдбазарын  
**Гэрэлтуяа**  
Ердийн гишүүн



Ванданцэрэнгийн  
**Баяржаргал**  
Ердийн гишүүн



Чулууны  
**Ганзориг**  
Ердийн гишүүн



Майнбаярын  
**Тулгат**  
Ердийн гишүүн



Ишдоржийн  
**Баттуяа**  
Хараат бус гишүүн



Барамсайн  
**Ганбат**  
Хараат бус гишүүн



Ванчигийн  
**Ганзориг**  
Хараат бус гишүүн



Чулуунзоригтын  
**Чинзоригт**  
Хараат бус гишүүн

Д/д	ТУЗ-ийн хурал зохион байгуулагдсан огноо	Хурлын хэлбэр	Шийдвэрлэсэн асуудлууд
1	2020.03.26	ээлжит бус	2019 оны ногдол ашгийн хэмжээнд өөрчлөлт оруулах Төсвийн тодотгол батлах тухай
2	2020.04.13	ээлжит	Хувьцаа эзэмшигчдийн хурал даргалагч томилох тухай
			Ажлын хэсэг байгуулах тухай
			Засаглалын журмууд шинэчлэн батлах тухай
			Сонирхлын зөрчилтэй хэлцлүүд батлах тухай
3	2020.07.17	ээлжит	2019 оны аудитлагдсан тайлангийн дүгнэлтийг батлах тухай
			ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Чулуунбаатарыг чөлөөлөх, түр гишүүн томилох
			Хөндлөнгийн аудит томилох тухай
			ТУЗ-ийн дэргэдэх Хорооны гишүүнийг нөхөн томилох
			Журмууд батлах тухай
4	2020.11.02	ээлжит	Сонирхлын зөрчилтэй хэлцлүүд батлах тухай
			Үл хөдлөх хөрөнгө худалдан авах тухай
			Зээлийн бүтээгдэхүүний нөхцөл батлах тухай
			Эрх олгох тухай
			Эрсдэлийн сангаас зээл хаах тухай
5	2020.12.11	ээлжит	Комплаенс хариуцсан ажилтан томилох
			Сонирхлын зөрчилтэй хэлцлүүд батлах тухай

Эчнээ хурлаар шийдвэрлэсэн асуудлын тоо: 15

# Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Хороод

Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ нь компанийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэжлийн түвшинд явуулах зорилгоор, Дотоод аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Санхүү, зээл, эрсдэлийн хороодтой байх бөгөөд уг Хороод нь Компанийн тухай хуульд зааснаар ТУЗ-аар хэлэлцэх асуудлуудтай холбоотой зөвлөмж гарган ТУЗ-д танилцуулдаг.

## Дотоод аудитын хороо

Дотоод Аудитын Хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, аудитын байгууллагыг сонгон шалгаруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

**Бүрэлдэхүүн:** Хорооны дарга ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Ганбат  
Хорооны гишүүнд: ТУЗ-ийн хараат бус гишүүн В.Ганзориг, ТУЗ-ийн хараат бус гишүүн И.Баттуяа, ТУЗ-ийн ердийн гишүүн М.Тулгат

## Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны зорилго нь компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин, урамшууллыг томъёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох асуудлуудыг хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах, чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

**Бүрэлдэхүүн:** Хорооны дарга ТУЗ-ийн гишүүн В.Баяржаргал  
Хорооны гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн В.Ганзориг, ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Ганбат



### Санхүү, зээл, эрсдэлийн хороо

Санхүү, зээл, эрсдэлийн хороо нь компанийн стратеги төлөвлөгөө, зээлийн үйл ажиллагаанд баримтлах бодлогуудыг боловсруулж ТУЗ-д танилцуулан батлуулах, компанийн хувьцааны үнэ цэнийг дээшлүүлэх, зээлийн эрсдэлийг бууруулахад хяналт тавьж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

**Бүрэлдэхүүн:** Хорооны дарга ТУЗ-ийн гишүүн Ч.Ганзориг

Хорооны гишүүд: ТУЗ-ийн гишүүн

В.Баяржаргал, ТУЗ-ийн хараат бус гишүүн

Б.Ганбат, ТУЗ-ийн гишүүн С.Гэрэлтуяа,


ТУЗ-ийн хараат бус гишүүн В.Ганзориг

## Ногдол ашгийн тайлан

Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 2 сарын 19-ний өдрийн 2020/4 тоот тогтоол, 2020 оны 3 сарын 26-ны өдрийн 2020/6 тоот тогтоолуудаар компанийн 2019 оны эцсийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчиддээ нэгж хувьцаанд 3.9 төгрөг буюу цэвэр ашгийн 50 хувь болох 1.092 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн.

Ногдол ашгийг 2020 оны хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр буюу 2020 оны 4 сарын 8-ны өдрийн байдлаар Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцааг эзэмшиж байгаа нийт хувьцаа эзэмшигчдэд олголоо.

Компанийн зарласан ногдол ашгийг 2020 оны 4 сарын 30-ны өдөрт багтаан Санхүүгийн Зохицуулах Хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүллээ.







# Үйл ажиллагаа

## Зээлийн үйл ажиллагаа (тэрбум)


Нийт Зээл олголт	<b>₮42.1</b>
Цахим зээл	<b>₮33.3</b>
Бизнесийн зээл	<b>₮5.2</b>
Хэрэглээний зээл	<b>₮3.6</b>

## Зээлийн багц (тэрбум)

Нийт зээлийн багц	<b>₮20.3</b>	100%
Цахим зээл	<b>₮11.6</b>	57.1%
Бизнесийн зээл	<b>₮6.9</b>	33.9%
Хэрэглээний зээл	<b>₮1.6</b>	8.0%
Бусад зээл	<b>₮0.2</b>	0.9%

## Зээлийн багц (тэрбум) **₮20.3**

Хэвийн	<b>₮17.2</b>	PAR	<b>15.1%</b>
Хугацаа хэтэрсэн	<b>₮1.2</b>	NPL	<b>9.4%</b>
Хэвийн бус	<b>₮0.6</b>	Сан	<b>6.6%</b>
Эргэлзээтэй	<b>₮0.7</b>		
Муу	<b>₮0.6</b>		



### Ард Апп/Fast Cash (мянга)

Апп таталт	637
Харилцагч	357
Зээлдэгчийн тоо	48.6
Зээлийн хүсэлт	467.7
Дундаж зээлийн хэмжээ	₮689

	Дүн (тэрбум)	Тоо
Нийт Зээл олголт	₮33.3	48,196
Нийт Зээл эргэн төлөлт	₮35.4	254,520
Зээлийн багц	₮11.6	

## Хүний нөөц

Ард Кредит ББСБ ХК-ийн Захирлуудын зөвлөл 2020 онд анх удаа албан ёсоор зохион байгуулагдаж, Гүйцэтгэх захирал, Стратеги, бодлого төлөвлөлт эрхэлсэн захирал, Маркетинг хариуцсан захирал, Ерөнхий нягтлан бодогч, Үйл ажиллагаа эрхэлсэн менежер гэсэн бүрэлдэхүүнтэйгээр компанийн өдөр тутмын болон цагийн үеийн чухал асуудлуудаар хуралдаж, шийдвэр гаргаж ажиллалаа.

Ард Кредитын үйл ажиллагааны бүтэц, хүний нөөц нь компанийн үндсэн чиглэл болох зээлийн үйл ажиллагаанд төвлөрдөг бөгөөд мэдээлэл технологи, дотоод аудит зэрэг функцийг толгой компаниас менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээгээр авч байна.

Ингэснээр үндсэн чиглэл, үйл ажиллагаанд илүү төвлөрч, бага зардлаар үйл ажиллагаагаа явуулах бололцоотой болдог.

Өнгөрөгч онд Шинэ төрлийн Коронавирус (Ковид-19)-ын улмаас бизнесийн байгууллагууд үйл ажиллагаагаа хумих, хүний нөөцөө цомхотгох арга хэмжээ авч байсан бол бид ажлын байрыг тогтвортой хадгалах, нийт ажиллагсдаа зайнаас ажиллуулах боломжоор хангах, тэдгээрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг тэргүүнд тавих, хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтад ажлын байрны тэгш эрхийн бодлого баримтлах зэрэг шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа.





Ажилтны эрүүл мэндийг дэмжиж ажилтан тус бүрийг 20 сая төгрөгийн хамгаалалт бүхий эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамруулав. Нөгөө талаар НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтууд болох "Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих", "Тэгш бус байдлыг бууруулах"-ыг дэмжиж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажлын байрны тэгш боломж олгох бодлогыг шат ахиулан хэрэгжүүлж эхлэв. 2020 онд Харилцагчийн үйлчилгээний төвийг сайжруулах төслийг амжилттай хэрэгжүүлснээр ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулж, дотоод бүтэц, зохион байгуулалтыг шинэчилж, өргөтгөсөн бүрэлдэхүүнтэйгээр ажиллах болов.

Нийт ажилчид 40

Эрэгтэй 14 - 35%  
Эмэгтэй 26 - 65%

Дундаж наслалт 30.0

# Нийгмийн хариуцлага

- ▲ Ард Кредит ББСБ ХК-ийн нийт ажиллагсад нэг өдрийн цалингаа ЗҮРХ МАРТАХГҮЙ аянд хандивлав.



- ▲ Ард Кредит ББСБ ХК нь МББСБХ-с санаачлан зохион байгуулсан хандивын үйл ажиллагаанд нэгдэж нийт 100.000.000 (Нэг зуун сая) төгрөгийн хандив цугларсныг Улсын Онцгой Комиссын даргад гардуулав.



# Эдийн засгийн орчин

## ЦАР ТАХАЛ БА МАКРО ЭДИЙН ЗАСАГ


2019 оны 12 сард БНХАУ-д Шинэ төрлийн Коронавирус (Covid-19)-ын халдвар дэгдэж, тухайн бүс нутагт хөл хорио тогтоож эхэлсэнтэй холбоотойгоор хил зэргэлдээ орших Монгол Улсын хувьд Шинэ төрлийн Коронавирусын халдварын болзошгүй эрсдэл нэмэгдсэн.

Үүнтэй холбогдуулан 2020 оны 1 сарын 24-ний өдөр Улсын онцгой комисс хуралдаж, түүнээс хойш УИХ, Засгийн газартай хамтран шинэ Коронавирусийн халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг түр зогсоох, олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарлах, хилийн боомтуудыг хааж, улс, хот хоорондын хөдөлгөөнийг хязгаарлах зэрэг арга хэмжээнүүдийг шат дараатайгаар авч хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд 2020 оны эхний хагаст

Коронавирусын халдварыг дотооддоо алдахгүйгээр барьж чадсан хэдий ч сүүлийн хагаст хөл хориог сулруулсантай холбоотойгоор цар тахал эрчимтэй нэмэгдэж эхэлсэн.

Цар тахал манай улсын эдийн засагт багагүй хохирол учруулсан бөгөөд 2020 оны эцсийн байдлаар, ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр, үйлдвэрлэлийн аргаар, өссөн дүнгээр) 18.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1 их наяд төгрөг буюу 5.3 хувиар агшсан байна. Уг бууралтад уул уурхай, олборлолтын салбар 371.6 тэрбум төгрөг (9.4%), тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар 281.5 тэрбум төгрөг (20.1%), бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар 256.9 тэрбум төгрөг (11.1%), бүтээгдэхүүний цэвэр татвар 205.3 тэрбум төгрөг (9.8%) тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.


### ДНБ их наяд төгрөг



Эх сурвалж: YCX, <https://1212.mn/>

Инфляцийн түвшин 2017 оны 12 дугаар сард 6.4 хувь, 2018 оны 12 дугаар сард 8.1 хувь, 2019 оны 12 дугаар сард 5.2 хувь гарч байсан бол 2020 оны 12 дугаар сард 2.3 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.9 пунктээр буурсан байна. Инфляци төв банкны зорилтот түвшнээс (8%) буурч байгаа нь эдийн засгийн идэвхи суларсныг илтгэж байна.

### Сарын инфляци, өссөн дүнгээр



Эх сурвалж: <https://www.mongolbank.mn/>



## ТӨСВИЙН БОДЛОГО

Коронавирусын улмаас хөл хорио тогтоож хил, гааль хаагдсантай холбогдуулан гадаад худалдааны эргэлт буурч, үүний дотор 2015 оноос 2019 он хүртэл тогтмол өсөлттэй буюу жилийн дундаж нийлмэл өсөлт нь 13 хувьтай байж 7.62 тэрбум ам.долларт хүрч байсан экспортын орлого энэ онд анх удаа 43.5 сая ам.доллаар буурч 7.58 тэрбум ам.долларт хүрсэн байна.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 9.4 их наяд төгрөг болж өмнөх оноос 13.6 хувиар буурсан, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 14.0 их наяд төгрөг болж өмнөх оноос 2.3 их наяд төгрөгөөр (19.7%) өсөж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 4.5 их наяд төгрөг (ДНБ-ий 12.2 хувь)-ийн алдагдалтай гарлаа.

## МӨНГӨНИЙ БОДЛОГО

Коронавирусын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкнаас 2020 онд бодлогын хүүг 4 удаа нийтдээ

Манай улсад Ковид-19 цар тахлын өвчлөл бүртгэгдэж эхэлсэн 5 дугаар сараас эхлэн аж ахуй нэгж байгууллагын ажилчдын НДШ-ыг "тэглэх", хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэн зэрэг шийдвэрүүд нөлөөлсөн байна. Мөн, өмнөх оноос нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 194.6 (8.2%) мянгаар, үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ 912.5 (2.4 дахин) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын санхүүжилтийг эх үүсвэрээр харвал, харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлтөөр 2.1 их наяд төгрөгийг, ЗГ-ын гадаад зээлээр 2.7 их наяд төгрөгийг санхүүжүүлж, дотоодын Засгийн газрын бонд болон зээлийн төлбөрт 0.4 их наяд төгрөгийг төлсөн байна. ЗГ-ын гадаад зээлийн санхүүжилт өмнөх оноос 2.4 дахин өссөн байна.

5 хувиар бууруулж 6 хувь болгосон. Мөн хэрэглээний зээлтэй иргэдэд үндсэн зээл, хүүгийн төлбөрөө 12 сар хүртэл хугацаагаар хойшлуулах боломжийг олгосон байна.

# Банк Бус Санхүүгийн Байгууллагын зах зээл

2020 оны эцсийн байдлаар Монгол Улсын санхүүгийн зах зээлд нийт 532 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь өмнөх оноос 1.1 хувиар буурсан үзүүлэлт юм. Үүнээс тайлант улиралд нийт байгууллагуудын дийлэнх нь болох 494 буюу 92.7 хувь нь зээлийн үйл ажиллагааг эрхэлж, 7.3 хувь нь зөвхөн гадаад валют арилжааны үйлчилгээг дагнан эрхэлж байна. Нийт хөрөнгийн хэмжээ 2020 оны эцсийн байдлаар 2.0 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 16.0 хувь буюу 276.8 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Салбарын нийт харилцагчдын 88.4 хувь нь эдгээр банк бус санхүүгийн байгууллагын

харилцагчид буюу технологид суурилсан зээлийн үйлчилгээг хүртэх боломжтой байна. Нийт зээлдэгчдийн 40.0 хувь нь зөвхөн гар утсаараа дамжуулан зээл авч байна.

Мөн салбарын зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн үйлчилгээний хүртээмж сайжирсан бөгөөд 100,000 хүн тутамд 26 ББСБ ногдож, салбарын зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 1.9 дахин нэмэгдэж 788.0 мянга хүрсэн бол нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар буурч 2.8 саяд хүрсэн дүнтэй байна.

Нийт хөрөнгө	₮2.0 их наяд
Нийт зээл	₮1.32 их наяд
Нийт орлого	₮408.8 тэрбум
Нийт харилцагч	2.8 сая
Нийт зээлдэгч	788.0 мянга

# Хараат бус аудитын тайлан



"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК  
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний  
далхийн сүлжээний бие даасан фирм

## Хураангуй санхүүгийн тайлангийн талаарх Хараат бус аудиторын дүгнэлт

Дэлхий нүүр 9 дөвөр, КНЕСКО  
тосгон, Сербетар дүүрэг, 3-р  
квартал, Улаанбаатар 14230,  
Монгол улс  
Т - 976 70 130744  
Ф - 976 70 130799

Oslo Tower, 9/F, UNESCO street,  
Sahlgrenska District 1, Ulaanbaatar  
14230, Mongolia  
T - 976 70 130744  
F - 976 70 130799

"Ард кредит ББСБ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

### Дүгнэлт

Бид "Ард кредит ББСБ" ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйцэтгэлийн тайланг (дараахд хамтад нь "хураангуй санхүүгийн тайлан" гэж) 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлангийн маяг"-д шавдсан бусад тайлбар тодруулгуудыг нэг бүрэн агуулаагүй тул "Ард кредит ББСБ" ХК-ийн аудитын тайлан бүрэн дүүрэн орлоггүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй юу ч дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд манай аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй.

### Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд зөрөг дүгнэлт өгсөн. Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудал нь компани нь эзэлгийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Банк бус санхүүгийн байгууллагын активыг илрүүлэх, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журмын дагуу тооцдог боловч олон нийтийн ашиг, өмчирхэл бүхий хувьцаат компанийн хувьд СТОУС 9 "Санхүүгийн хэрэглүүр"-ийг хэрэглүүлэх шавдлагагай гэж үзсэн.

### Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгуулсан баталсан холбогдох дүрэм, журмын дагуу бэлтгэж, үнэн зөв тогжуулах үүрэгтэй.

### Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын "Аудитын тухай" хуулийн дагуу хийсэн аудитын үндэслэлээр эзгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.



## Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
<b>Хөрөнгө</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,249,682	1,873,425
Богино хугацаат хөрөнгө оруулалт	89,000	79,000
Зээл	18,949,256	17,766,357
Бусад санхүүгийн хөрөнгө	1,793,317	589,074
Бусад эргэлтийн хөрөнгө	3,285,543	1,552,789
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>27,366,798</b>	<b>21,860,645</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
<b>Үндсэн хөрөнгө, цэвэр</b>	<b>259,291</b>	<b>107,404</b>
<b>Биет бус хөрөнгө, цэвэр</b>	<b>2,028,939</b>	<b>1,125,611</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,288,230</b>	<b>1,233,015</b>
<b>Нийт хөрөнгө</b>	<b>29,655,028</b>	<b>23,093,660</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>		
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Банк, санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зээл	2,664,401	2,540,636
Өрийн бичгээрх өглөг	3,661,000	1,995,000
Бусад эх үүсвэр	7,845,836	5,420,675
Бусад өр төлбөр	3,228,325	1,474,612
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>17,399,562</b>	<b>11,430,923</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
Урт хугацаат зээл	867,977	923,216

## Санхүүгийн байдлын тайлан (үргэлжлэл)

Хойшлогдсон татварын өр	134,219	47,092
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,002,196</b>	<b>970,308</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>18,401,758</b>	<b>12,401,231</b>
<b>Эздийн өмч</b>		
Эзэмшигчдийн өмч	6,429,896	6,848,467
Бусад өмч	976,953	240,731
Хуримтлагдсан ашиг	3,846,421	3,603,231
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>11,253,270</b>	<b>10,692,429</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>29,655,028</b>	<b>23,093,660</b>

## Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
Хүүгийн орлого	6,306,995	3,844,786
Хүүгийн зардал	(2,122,526)	(1,288,812)
<b>Цэвэр хүүгийн орлого</b>	<b>4,184,469</b>	<b>2,555,974</b>
Хүүгийн бус орлого	2,075,579	2,794,381
Хүүгийн бус зардал	(3,369,727)	(2,124,625)
<b>Цэвэр хүүгийн бус орлого</b>	<b>(1,294,148)</b>	<b>669,756</b>
<b>Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг</b>	<b>2,890,321</b>	<b>3,225,730</b>
Болзошгүй эрсдэлийн зардал	(1,326,564)	(797,955)
<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг</b>	<b>1,563,757</b>	<b>2,427,775</b>
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	155,944	43,798
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	(292,586)	(36,173)
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>1,427,115</b>	<b>2,435,400</b>
Орлогын албан татварын зардал	(186,340)	(248,822)
<b>Цэвэр ашиг</b>	<b>1,240,775</b>	<b>2,186,578</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	830,637	-
Виртуал хөрөнгийн бодит үнэ цэнийн үнэлгээний нэмэгдэл	736,222	-
Виртуал хөрөнгийн тайлант хугацаанд хэрэгжсэн олз	94,415	-
<b>Орлогын нийт дүн</b>	<b>2,071,412</b>	<b>2,186,578</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	<b>4.5357</b>	<b>7.8092</b>

## Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 1 сарын 1-ний үлдэгдэл</b>	<b>2,100,000</b>	-	-	-	<b>1,657,384</b>	<b>3,757,384</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,100,000</b>	-	-	-	<b>1,657,384</b>	<b>3,757,384</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	2,186,578	2,186,578
Өмчид гарсан өөрчлөлт	700,000		4,048,467			4,748,467
<b>2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,800,000</b>	-	<b>4,048,467</b>	-	<b>3,843,962</b>	<b>10,692,429</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	240,731	(240,731)	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,800,000</b>	-	<b>4,048,467</b>	<b>240,731</b>	<b>3,603,231</b>	<b>10,692,429</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	1,240,775	1,240,775
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	830,637		830,637
Өмчид гарсан өөрчлөлт	-	(64,396)	(354,175)	-		(418,571)
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	(1,092,000)	(1,092,000)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	(94,415)	94,415	-
<b>2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,800,000</b>	<b>(64,396)</b>	<b>3,694,292</b>	<b>976,953</b>	<b>3,846,421</b>	<b>11,253,270</b>

## Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	2020 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>55,347,645</b>	<b>45,563,171</b>
Харилцагчдад олгосон зээлийн эргэн төлөлт /үндсэн зээл/	39,048,119	31,472,376
Итгэлцэл, татан төвлөрүүлсэн хөрөнгө	9,017,906	4,304,143
Зээлийн хүүгийн орлого	5,175,231	3,529,416
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	1,550,763	1,696,830
Бусад үйлчилгээний орлого	555,626	4,560,406
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>(53,720,621)</b>	<b>(48,024,948)</b>
Харилцагчдад олгосон зээлд төлсөн	(42,113,672)	(41,696,780)
Итгэлцэл татан төвлөрүүлсэн хөрөнгө төлөлт	(6,933,486)	(3,191,656)
Итгэлцлийн үйлчилгээний хүүгийн зардалд төлсөн	(1,136,933)	(1,556,415)
Үндсэн ба нэмэгдэл цалинд төлсөн	(754,937)	(690,378)
Түрээс, менежментийн зардалд төлсөн	(321,050)	(34,172)
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	(294,280)	(101,400)
Татвар, даатгалд төлсөн	(280,767)	(243,234)
Бондын хүүгийн зардалд төлсөн	(265,301)	(252,606)
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	(109,744)	(7,282)
Нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн	(105,460)	(86,911)
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(76,947)	(19,293)
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардалд төлсөн	(18,985)	(75,959)
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардалд төлсөн	(18,417)	(31,910)
Албан томилолт, сургалтын зардалд төлсөн	(9,894)	(27,291)
Ажилтнуудад олгосон нөхөн олговор, тэтгэмжид төлсөн	(3,605)	(9,661)



## Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	(1,277,143)	(1,601,540)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,627,024</b>	<b>(2,461,777)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>54,834</b>	<b>146,084</b>
Харилцах, хадгаламжийн хүүгийн орлого	39,455	134,474
Ногдол ашгийн орлого	15,379	1,208
Бусад мөнгөн орлого	-	10,402
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>(363,840)</b>	<b>-</b>
Хөрөнгө худалдан авахад төлсөн мөнгө	(363,840)	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(309,006)</b>	<b>146,084</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>5,452,513</b>	<b>5,895,207</b>
Бонд гаргалтаас хүлээн авсан мөнгө	2,538,000	1,205,707
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	2,914,513	4,689,500
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>(5,394,274)</b>	<b>(2,829,818)</b>
Банк, санхүүгийн зээлийг төлсөн мөнгө	(1,840,636)	(1,995,818)
Бондын төлбөрт төлсөн мөнгө	(1,461,198)	(834,000)
Ногдол ашигт төлсөн мөнгө	(1,092,000)	-
Үнэт цаас худалдан авахад төлсөн мөнгө	(1,000,440)	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>58,239</b>	<b>3,065,389</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,376,257</b>	<b>749,696</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,873,425</b>	<b>1,123,729</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>3,249,682</b>	<b>1,873,425</b>

## Хамтран ажиллагч байгууллагууд



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Монгол Банк



Санхүүгийн зохицуулах хороо



Монголын Хөрөнгийн бирж



ҮЦТХТ



Grape City



Монгол Шуудан ХК



Nomadic off-road



Хасбанк



Most money



CallPro





Хүчтэй. Хамтдаа.